

now the Grand families still have been the education centre.

### Ашигласан ном:

#### I. Монгол хэл дээр:

1. Бао Хай шинь Мандаг уулын хадны зураг. Өвөрмонголын өөртөө засах орны "Солонгос" сэтгүүл. 1997. №2.
2. БНМАУ-ын Угсаатны зүй. I. УБ., 1987.
3. Д. Гонгор Халх товчоон. II. УБ., 1978.
4. Д. Дорж Чулуун зөвсгийн үе. "Археологийн судлал" Т. XII, Ф. 1.
5. Д. Майдар, Л. Дарьсүрэн Гэр. УБ., 1974.
6. Монголын угсаатны зүй. III. УБ., 1997.
7. Т. Намжил. Монголчуудын гэр бүлийн хүмүүжлийн уламжлал. УБ., 1996. I дэвтэр. Редактор: А. Очир.
8. Т. Намжил. Монгол ба Зүүн хойт Азийн гэр бүл. УБ., 1996. II дэвтэр. Редактор: Академич, доктор Ч. Далай.
9. Т. Намжил, Монгол, Өрнө, Дорно: Гэр бүлийн зан заншлын уламжлал, холбоо. III дэвтэр. УБ., 1999. Редактор: Академич Ч. Далай.
10. Т. Намжил. Монгол гэрийн ёс уламжлал. IV дэвтэр. УБ., 1999. Редактор: А. Очир.
11. Б. Сумъяабаатар. Монгол, Солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудал. УБ., 1975.
12. Ф. Энгельс. Өрх гэр, өмч хөрөнгө, төрийн үүсэл. К. Маркс, Ф. Энгельс. Түүвэр зохиол. III. УБ., 1971.

#### II. Солонгос хэл дээр:

13. Ким Юхйог. "Шинэ тосгон хөдөлгөөн ба гэр завтарт хот" II /Монгол, Солонгос хэл дээр/. Сеул. 1991.
14. Чве Чже Сок. Хангүк Качок йонгу /Солонгос гэр бүлийн судалгаа/ Сеул. 1975.

#### III. Англи хэл дээр:

15. Korean Family and Kinship. Seoul 1997.
16. Korea Focus. 1997. №3, 1998. №1.

### III. ГЕОПОЛИТИК. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ

#### МОНГОЛ УЛСЫН ТАДААР ЯВУУЛЖ БҮЙ БНХАУ-ЫН ГЕОПОЛИТИКИЙН ЗАРИМ АСУУДАА

МУИС, ОУХС-ийн багш,  
Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин Х.Олзвов

1989 оны 5 дугаар сарын 16-нд Дэн Сяопин М.С.Г орбачевтой уулзаж хоёр гүрний харилцааг хэвийн, сайн хөршийн хэмжээнд эргүүлэн оруулахаар тохиролцсон билээ. Энэ уулзалтынхаа үеэр Дэн Дэлхийн II дайн дуусах дөхөхөд АНУ, Англи, ЗХУ Ялтад нууц хэлэлцээр байгуулан дайны дараахь нөлөөний хүрээгээ хуваахдаа Хятадын эрх ашигт залруулшгүй хохирол учруулсныг дурдаад энэ баримтыг тэмдэглэхдээ „зөвлөлтийн нөхдөд өнгөрсөн үеийг бид хэрхэн ойлгож байсан хийгээд өнгөрсөн хугацаанд юу бидний санаа бодлыг зовоож ирсэн бэ гэдгийг дуулгах гэсэн юм.“ гэж дурджээ. Тэгээд Хятад, Монголын харилцааг сөхөж, хоёр орны хооронд аль эрт хэвийн дипломат харилцаа тогтоож, янз бүрийн гэрээ хэлэлцээр байгуулж, хоёр улсын хилийг тогтоон демаркац хийсэн гэж ярьсан байдаг.<sup>1</sup>

Энэ үгэнд "алдсан" нутгийн тухай гомдол, ирээдүйд юу ч билээ гэсэн санаархал зэрэг цухалзаж байгаа нь илт байна.

Хятадын эүгээс явуулж буй энэ "алдгдсан нутаг" гэгч бодлого нь түүхийн нутгачанд нэг ил тод болж, нэг бүдгэрч ирсэн билээ. Гэтэл монголчууд нь уламжлалт бэлчээрийн мал аж ахуйгаа эрхлэн түүхийн олон зууны туршид тариалангийн Хятадаас ямагт тусгаар байсан түүх бий. Энэ байдал Хятадыг Монголчууд захируч байсан Юань гүрний үед ч (1271-1368), Хятад Монгол хоёул Манжийн ноёрхолд байсан үед ч (1644-1911) хадгалагдаж байлаа. 1921 оноос хойш ч Монгол улс тусгаар тогтносон, Хятадаас үл хамаарах орон байсныг хэлэх хэрэгтэй. Харин ЗХУ Дундад Иргэн Улсыг эрхшээлдээ авах, нөлөөндөө оруулах бодлогынхоо үүднээс Монголын араар Хятадтай тохиролцож 1924 оны хэлэлцээрээр Монгол бол Хятадын хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн боловч Хятадууд засаг захиргааны хувьд ч, цэрэг улс төрийн хувьд ч

Монголд хяналтаа тогтоож чадаагүй билээ. Ингэхийг Оросын тал ч хүсээгүй нь мэдээж.

Сүн Ятсен 1912 онд түр ерөнхийлөгч болоходоо Хятадыг „Үнэнхүү нэгтгэх“ ээ тунхаглахдаа Хятад, Манжуур, Монгол, Синьзаны лалын шашинт нутаг, Төвдийг хамааруулсан гэдэг. 1936 онд Мао Зэдун АНУ-ын сэтгүүлч Эдгар Сноуд ярилцлага өгөхдөө „Хятадад ардын хувьсгал ялахад Гадаад Монгол өөрийн хүсэлтээр аяндаа Хятадын холбооны хэсэг болно“<sup>2</sup> гэсэн бөгөөд энэ санаагаа Мао хожим нь хэд хэдэн удаа давтан илэрхийлсэн билээ. 1949 оны эцэс, 1950 оны эхээр Мао ЗХУ-д анхны аяллага хийхдээ 1945 онд гоминданий Хятад, ЗХУ-ын хооронд байгуулсан найрамдлын гэрээг шинэчлэн хэлэлцэж „бусад зарим“ асуудал хэлэлцээний нэг нь Гадаад Монголын асуудал байлаа. Шинэ гэрээ байгуулах асуудал хэлэлцэх үед Монголын асуудлыг сөхөх тухай Жоу Энлайтай ярилцаж байхдаа Мао „Бид бартай хамт хооллож түүний гүнцэгнээс махны тасархай урж авах ёстой“ гэж байсан боловч Порт-Артур, Далынйгаас Оросын цэргийг гаргах, зээл авах, худалдааны гэрээ байгуулах зорилгынхоо үүднээс аргагүйн эрхэнд Оросын байр суурийг харгалзахад хүрчээ. Тэрбээр урандаа уруулаа тас зууж хэсэг удсанаа “энэ асуудал (Монголын асуудал-Х.О) гэрээнд хөндөгдөх ёсгүй” гэж хэлсэн гэдэг. Дараа нь Н.Хрущёвд 1954 онд улгит санаагаа давтаж, Японы социалистуудад 1964 онд гомдлоо илэрхийлж байснаас үзвэл Мао үхэн үхтлээ Монголыг нэгтгэх санаагаа хаяагүй билээ. Ийнхүү Монгол бол Хятадын хэсэг гэсэн үзэл санаа өнөө ч төрийн “алтан хайрцаг”-ны бодлогын хүрээнд байсаар байгааг ОХУ суларсан өнөө үед Монгол руу БНХАУ хичнээн анхаарч байгааг 1990 оноос хойш БНХАУ-ын бүх гол удирдагч Монголд айлчилж, манай удирдагчдыг урин аваачиж манай талаас тавьж буй санал, санаачилгыг идэвхтэй дэмжиж, худалдаа эдийн засгийн харилцаагаа эрс өргөжүүлж, хамтарсан аж ахуйн пүүс, компанийн тоогоор манлайлах болсон зэргээс харагдана.<sup>4</sup>

Монголын хувьд явуулж буй Хятадын энэ Lebensraum (орон зайгаа тэлэх)-ын бодлогыг “Geopolitics of Lost Land” (Алдагдсан нутгийн геополитик)-ийн бодлого гэж нэрлэж судлагдахдад толиглуулж байна. Нутгийн хэсэг гэж үзэх үзлийг нь ингэж нэрлэмээр.

Энэ зууны эхээр А.Макиндер “хаартлэнд”-ын онолоо тунхаглаж тодорхойлохдоо Хятадын “шар аюул” (“Yellow Peril”)-аас болгоомжлуулсан билээ. Энэ “шар аюул” нь зөвхөн газар нутгийн холбоотой бус “lost land” (алдагдсан газар)-ын бодлого ч биш, бас орчин үед өмнө зүгээс шилжих хүний урсгал хөдөлгөөн юм. 250 сая хүн ажиглгүйдэж гадагшаа цагаачлах бодлогыг төр нь өөшүүлж байгаа өнөөгийн Хятадын иргэд Сибирь, Оросын Алс Дорнодод сая гаруйгаар тоологдох болсныг дурдах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл Монгол орныг Хятадын иргэдийн цуваа ороон авч бас нутгийн гүн рүү нэвчиж байгаа нь өмнө зүгээс ирж болох аюулын том дохио юм.

Канадын Викторийн их сургуулийн проф. Роберт Б.Бедески нэгэн өгүүллийнхээ нэг хэсгийг “Монгол хүн амын бамбай (буюу завсрын зөөлөвч) улс мөн үү?” гэж гарчигласан байна. Хятадын хууль бус цагаачид Монголд арван мянгаар тоологдож буйг дурдаад “Хятадаас гарч явахыг хүсэгчдийн олонхи нь Баруун Европ, Хойд Америкийн үйлдвэржсэн орнуудыг эрхэмлэж байгааг Монгол орон ойрхон учраас худалдаа хийх болон илүү сонирхогдсон орон руу цагаачлах дамжин өнгөрөх боломж нээж байна.” гэж цохон тэмдэглэжээ.<sup>5</sup>

Оросын Алс Дорнод, Сибирьт оршин суугчид хятадуудын нэвчилтээс эмээж байгааг Мичиганы Улсын Их Сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн багш Владимир Шлапентох цохон тэмдэглэхдээ тэд “Хятадын арми тэдний нутгийг шууд нэгтгэнэ гэж санаа зовоогүй, харин хятадууд тэдний өдөр тутмын амьдралд дайран орж буйд гүнзгий уурлан уцаарлаж байна.”<sup>6</sup> гэжээ. Тэрээр Оросуудын гомдлыг жагсаан бичсэний дотор дорхи зүйлийг дурджээ. Үүнд:

- Оросын хувьчилсан пүүс, түүнчилэн үл хөдлөх хөрөнгийг булаан авах;
  - Баян хятадууд орон сууцыг эзэмших болж байгаа;
  - Нутгийн хүнд сурталтнуудыг хятадын бизнесменүүд авилгалд автуулж байгаа;
  - Оросын стратегийн түүхий эдийг хямдхан худалдан авч байгаа;
  - Ховор ан амьтныг алж устгаж ашиглаж эхэлсэн;
  - Гэмт хэрэг, өвчин эмгэгийн тархалт их болсон явдал гэжээ.
- Энэ бүхэн Монголын хувьд бас анхаарах ёстой, ярьж бичиж

буй зүйл билээ. Ийнхүү Хятадын геополитикийн "ранланд"-ын бодлогын "шар аюул" хаа сайгүй мэдрэгдэж байна. "Шар аюул" бол босоо, хэвтээ байх хоёр хэлбэртэй байдаг.

Өөр нэг аюул бол Хятадын болон Өрнөдийн соёлын нөлөө дэлгэрэх явдал. Соёлын "шар аюул" чимээгүйхэн навчих нөхцөл бололцоо сүүлийн 10-аад жилд эрс нэмэгдсэн байна. Манай залуус, хүүхэд Хятадад боловсрол эзэмших, эсвэл хятад хэлийг нутагтаа сурах, түүнчилэн БНХАУ-ын төв төлөвиз, ӨМӨЗО-ны төлөвизийг өдөр бүр үзэх боломжтой болж монголчууд хятадын соёлын туралтад цаг, минут тутам өртсөөр байна. Гадаадад боловсрол олсон хүмүүс тэр нутгийнхаа хэл, заншилд ямар нэг хэлбэрээр өөрийн эрхгүй автагдаж цаад улс нь ч соёлын геополитикийн ач холбогдлыг мэдэрсээр байдаг нь нууц биш. 1999 оны намар "25 дугаар суваг" төлөвизээр явсан Тайваний "Хуаньжу Гэг" гэдэг олон ангит кино хэнд хэрэгтэй, юуг сурталчилж байсныг эргэн эргэн бодмоор. Монголын Үндэсний төлөвиз, "25 дугаар суваг", "Eagle" гэх мэт төлөвиз үндэсний соёл түүх, танин мэдэхүйн нэвтрүүлгээ бараг орхигдуулаад байгаа энэ үед Хятадын соёлын "шар аюул" эрчимжсээр байгааг тэмдэглэе.

Монгол-Хятадын харилцааны түүхийг үзвэл, энэ хоёр орон Оростой хэрхэн харилцаж байсан өнгө аясыг агуулж байснаар барахгүй Монгол, Хятадын харилцаа нь Монгол, Зөвлөлтийн харилцааны хувьд захирагдах, харьяалагдах (subordinate) шинж чанартай явж иржээ.<sup>7</sup> Үнэндээ ЗХУ хэдэн арван жилийн турш Монголын "өмгөөлөн ивээгч бөгөөд давамгайлалч хүч" байсныг түүх гэрчилнэ. Үүнээс гадна Монгол Хятадын харилцаанд нөлөөлсөөр ирсэн, нөлөөлж ч буй хүчин зүйлүүдэд юуны өмнө хоёр орны түүхэн харилцааны уршиг, ялангуяа "алдагдсан газар нутаг" гэж Монголыг үзэх Хятадын түүхийн ойлголтыг оруулах хэрэгтэй. Дээр иш татсан судлаач Елизабет Е.Грин ч ийм бодолтойгоо өгүүлэлдээ дурджээ. АНУ-ын геополитикийн Збигнев Бжезинский "Агуу их шатрын хөлөг" гэсэн номондоо Монгол, Хятадын харилцааны байдал төлөв, БНХАУ-ын геополитикийн шинж төрхийг товч ч гэсэн тодорхойлж зарим санаа хэлсэн байна. Үүнд:

"Хятадын сурагчид өөрийн орны түүхээс бүр 1840 онд Хятадын эзэнт улс ЗӨА-ийн нутаг дэвсгэр, Малакскийн хоолой, Бирм, өнөөгийн Бангладешийн бүс нутгууд, түүнчилэн Балба,

өнөөгийн Казахстаны зарим хэсэг, бүх Монгол, болон Амур мөрөн далайд нийлж буй хэсгээс арагших, одоо Оросын Алс Дорнод гэж нэрлэгддэг бүс нутаг дээр оршин тогтнож байлаа гэж мэдэж байгаа" гэжээ. Тэр үе нь Монгол, Хятад аль аль нь Манжийн дарлалд байсан үеийг хэлж буй өнөөгийн сурагчид, залуучууд яаж ойлгох билээ. Ийм агуулгатай түүхийн ном ч бичиж 1993 онд зарж байсныг манай тал олж эсэргүүцэл илэрхийлж номын тавиураас хураалгуулсан билээ.

"...Оросын холбоотон байхаа больсон бөгөөд тусгаар тогтнолыг нь Хятад дургүйвтэрхэн хүлээн зөвшөөрсөн Монгол Улстай тогтоосон харилцааны нь шинж төрхийг мөн л тэр эдийн засгийн хүч чадал тодорхойлж байна." гэжээ.

Ер нь БНХАУ-ын геополитикийн онцлог нь гео-эдийн засгийн салбар зонхилсон, эргэн тойрны орнуудынхаа эдийн засаг, санхүүгийн салбарт ил, далдаар бэхжих, нөлөөний хүчтэй хүрээтэй болох явдал байдаг. Тайландын 100 хамгийн хүчирхэг компаниудын олонхийн эздийн овог нэр нь нутгийнх боловч хэрэг дээрээ Хятад угсаатан толгойлсон буюу тэднээс хараат байдаг компани бөгөөд тэд ч бие биеэ мэддэгээр зогсохгүй эх орны эдийн засгийн 75 хувийг гартаа төвлөрүүлсэн байдаг гэж "Саут Чайна Морнинг Пост" сонинноос иш татаж ГХЯ-нд илтгэж байснаа зохиогч тодорхой санаж байна. Одоо ч эдийн засаг, санхүүгийн талаар сулавтар хөгжилтэй боловч байгалийн баялаг ихтэй Оросын Алс Дорнод, мөн Өмнөд Хятадын тэнгисийн эх газрын бүс Төв, Дундад Ази гэх мэт байгалийн баялаг арвинтай газрууд руу Хятадууд тэмүүлж шургалан орсоор буй З.Бжезинский ч тэмдэглэжээ. Ийм учраас Монголтой харилцах өнгө аясыг мөн л тэр эдийн засгийн хүч чадал тодорхойлж байна гэж З.Бжезинскийн хэлсэнгүй санал нийлэхээс аргагүй. БНХАУ иймэрхүү замаар ойрын 25 жилийн дотор 150 орчим жилийн өмнөх эзэнт гүрнийхээ (Манж-Цин улсын үе) геополитикийн нөлөөг сэргээх, бүр цаашлаад Пакистаныг оролцуулан тэлэх алсын бодлого барьж буй З.Бжезинский баримтаар нотлон өгүүлжээ.<sup>10</sup>

Эдийн засаг нь хараат буюу нөлөөний хүрээнд автаад ирэхээр "Энэ талаар Бээжинд юу гэж үзэж байгаа бол?" гэсэн асуулт ямар ч асуудал гарахад толгойд орох гээд байх болно. Иймэрхүү байдалд орсон Хятадын нөлөөний хүрээг "хүндэтгэлийн хүрээ" гэж

нэрлэж ч болох юм хэмээн иш татаж буй З.Бжезинский хэлжээ. Иймд Монгол улсын үндэсний язгуур эрх ашигт нийцсэн холч, мэргэн бодлого явуулж хэзээ ч тэр "хүндэтгэлийн хүрээ"-нд орохгүй байх нь манай улсын улс төрчид, дипломатчид, судлаачдын эрхэм зорилт мөн. Энэ нь БНХАУ-тай харилцаагаа цаашид ч хөгжүүлэхэд огтхон ч саад болох ёсгүй боловч манай төрийн "алтан хайрцангы бодлого"-д зайлшгүй байх зүйл.

Харин бид БНХАУ-ын өсөн нэмэгдэж буй үндэсний нийт хүч чадал, бүс нутгийн гүрнээс дэлхийн хэмжээний их гүрэн болох эрмэлзэл, нөлөөний хүрээгээ тэлэх, бэхжүүлэх арга барил зэргийг гүнзгий судлан улмаар академич Н.Ишжамц агсаны онож хэлснээр "ер нь зэргэлдээх гүрнүүдийн зүгээс ямар бодлого баримталж, яаж ч сүрхий арга явуулга хийлээ гэсэн түүнээс бага буурай улс илүү юм уу, ядаж тэнцүү нарийн арга бодлого сийлэн байж аврагддаг жамтай" <sup>11</sup> гэсэн зарчмыг барин ажиглах нь төрийн бодлогын оньсон түлхүүр мөн.

БНХАУ-ын геополитикийн зорилго, чиглэлийг авч үзэх, батлан хамгаалах буюу цэргийн бодлого, түүний геополитикийн агуулгыг орхигдуулж болохгүй нь мэдээж.

Хэдийгээр эдийн засгийн хувьд эмзэг байдал, бусдаас хамаарах тал нь өсч буй ч дэлхийн төвшингийн эдийн засагтай, төвлөрсөн засаглалтай Хятад улс хилийнхээ гадна хүч хэрэглэхэд шаардагдах асар их нөөц бололцоотойг цэргийн мэргэжилтнүүд тэмдэглэдэг. Цөмийн зэвсгийн нөөцөөрөө дэлхийд гуравт орж, цэргийн тоогоороо нэгд ордог энэ орон 1990-ээд оноос Ардын засгийн түүхэнд гараагүй таатай, энх тайван орчныг эргэн тойрондоо бүрдүүлсэн гэж нам, төрийн дээд зиндаанд дүгнэн ярихын хамт цэргийн зардлаа жил бүр хоёр оронтой тоогоор нэмэгдүүлсээр байгааг хэлэх хэрэгтэй. 1996-1997 оны санхүүгийн жилд зарласан батлан хамгаалах зардал нь 9.72 тэрбум ам.доллар байсан боловч энэ нь хэрэг дээрээ 38.6-48.25 тэрбум ам.долларын хооронд байсан гэж АНУ эрдэмтэн Самуэл С.Ким нотолсон байна. <sup>12</sup> Хэдийгээр БНХАУ-ын зэвсэгт хүчин техник, технологийн болон орчин үеийн цэргийн бусад үзүүлэлтээр АНУ болон бусад гүрний хэмжээнд хүрэхэд хол байгааг Өрнөдийн болон Оросын олонхи судлаач, шинжээчид тэмдэглэж байгаа боловч хил залгаа, бага буурай манай орны хувьд яав ч сэтгэл амраах дүгнэлт биш билээ.

Ер нь Хятад "үндэсний бүрэн хүч чадал" ("жүнхэ гуоли") нь дэлхийн төвшингийн их гүрэн болох зайлшгүй нөхцөл бөгөөд түүний хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг нь цэргийн хүч чадал мөн гэж үзсээр ирсэн юм. Цэргийн хүчээ бүх талаар зузаатгахад эдийн засгийн эрчимтэй хөгжил суурь нь болж байгаа бөгөөд ийнхүү "үндэсний бүрэн хүч чадал"-аа хангах нь геополитикийн давшингүй хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэс гэж үзсээр байгаа Бээжингийн үйл ажиллагаанаас харж болно. Евразийн өмнөд хэсэгт байрладаг орны хувьд БНХАУ төглүүрократын чиг бодлогоо хэрэгжүүлэх талаар ихээхэн анхаарахын хамт римлэндийн хувьд талассократын чиглэлээр бэхжихийг эрмэлзэж олон улсын байдал, хүчний харьцаа, Хятадын "үндэсний бүрэн хүч чадал"-ын өсөлтийг харгалзан энэ хоёр чиглэлээ уралдуулан "толгож" ирлээ. Цаашилбал, сансрын хөлөгтэй болж аэрократ, эфирократын талбарт байр суурь эзлэн батжихыг яараачилж байна.

"Хүйтэн дайн"-ы дараахь геополитикийг нь нарийвчлан үзвэл, найауаг quo fit гуап ("тэнгис бол үндэсний нутаг дэвсгэр мөн") гэсэн үзэл баримтлалд мэдэгдэхүйц ач холбогдол өгч далай тэнгисийн усан хилээ тодорхойлсон хууль батлах, эх газрын эргээ хамгаалах стратегиас далайд эдийн засаг, стратегийн ашиг сонирхлоо идэвхтэй хамгаалах номлолд шилжих зэрэг арга хэмжээ авахын хамт БНХАУ-ын стратеги-чид shengsuл kongjiaп (lebensraum буюу амьдрах орон зай)-ыг хамгаалах, тэлэх талаар улам тодорхой хэлэлцэх болжээ.

Тэд дээрх номлолынхоо хүрээнд юуны өмнө Энэтхэгийн далай, Өмнөд Хятадын тэнгис, Зүүн Хятадын тэнгис, сансрыг багтааж байгаа хэдий ч Ази тивд бүхэлд нь давамгайлсан цэргийн их гүрэн болохыг эрмэлзэж буй Самуэл С.Ким онцлон тэмдэглэжээ. Ази тив бол Хятадын хүч, нөлөөллийн төв бөгөөд зүг бүрт цацарч "үргэлж томорч байх тойргийн" цөм болох ёстой гэж БНХАУ-д үзэх болжээ. Хятадын хараа хяналт, нөлөөний энэ тойрогт Монгол Улс орж буй нь түүний геополитикийн нэг онцлог билээ.

Хятад эртнээс яналш өөрийгөө "Дундад эзэнт улс", "Дундад иргэн улс" гэж нэрлэж ирсэн агаад тэрхүү Жун Гуо буюу Хятад гэсэн нэрэнд Хятадын геополитикийн нэг гол утга оршиж байгаа гэж эрдэмтэд үзэж байна. Энэ нь нэг талаас Хятад бол эх газрын,

тэр тусмаа Евразийн чиглэлтэй, нөгөөтэйгүүр эх газар дахь хил нийлсэн улс орнуудыг өөрийн нөлөөний хүрээнд, эсвэл зээгнэн байх эрмэлзэлтэйг харуулна.

Хятад ийнхүү эх газрын "Дундад улс"-ын геополитиктойгоос гадна Зүүнээс Өмнөд хүртэлх урт далайгаар хүрээлэгдсэн Ripland (эргийн бүс) буюу далайн орон юм. Үүнийг геополитикийн угтаар авч үзвэл БНХАУ бас далайн геополитиктой орон юм.

Оросын геополитикч А.Дугиний үзэж буйгаар Хятад буюу Дундад иргэн улс нь XIX зууны эхнээс 1949 он хүртэл атлантизмын чиг баримжаатай байсан бөгөөд Өрнөдийн хувьд Евразийн эргийн бааз нь болж байв.

1949-1958 онд Евразийн чиглэлтэй, Оросыг дагалдсан геополитиктой улсын шинжтэй байжээ.<sup>13</sup> Дараа нь хэсэг хугацаанд аварга буюу түржигдмэл байдалд орсноо 1970-аад оны дундаас Өрнөдтэй идэвхтэй харилцаж атлантизмын геополитикийн бүтцэд дахин орж эхэлжээ. Энэ нь Хятадын нээлттэй бодлогыг бэхжүүлж, Өрнөдийн техник технологийг авах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, улмаар Хятадын эдийн засаг, хөгжлийн зорилтууд, "дөрвөн шинэчлэл"-ийн бодлогыг хэрэгжүүлэх геополитик, гео-эдийн засгийн ойрын ба хэтийн бодлогодтой нь холбоотой.

Хятадын геополитикт нөлөөлж буй хөгжлийн хүчин зүйлүүд ч бий. Тухайлбал:

- Байгалийн баялгаар харьцангуй хязгаарлагдмал;
- Нутаг дэвсгэрийн хувьд давчуу, 1.2 тэрбум хүн амаа багтааж ядан буй;
- Хүн ам олонтой, ажиллах хүч их тул ажлын хөлс бага;
- Дэлхийн том зах зээлийн нэг;
- Нээлттэй эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлж, гадаадын хөрөнгө оруулалт, техник технологийн ололтыг нэвтрүүлэх төрийн төлөвлөгөөт бодлого явуулж байгаа;
- Нээлттэй бодлого, эдийн засгийн шинэчлэлээ хэрэгжүүлэхдээ гадаад дахь цагаачид, талархагчдаа дээд зэргээр ашиглах бодлого явуулж буй;
- "Их Хятад"-ын буюу Хятадын нийтийн зах зээлийг БНХАУ, Тайвань, Санган, Аомэнь, Сингапурын оролцоотойгоор байгуулах чиглэлээр интеграциллыг хөгжүүлж, геополитикийн асар том нэгдэл бий болгох, алсын бодлого хэрэгжүүлж буй;

Хятадын эдийн засгийн ерөнхий чадавхийг хурдан нэмэгдүүлж цэргийн хүчээ зузаатгах арга хэмжээг тууштай авч явуулж байгаа зэргийг дурдахад л XXI зууны дэлхийн их гүрний геополитикийн дүр зураг, түүний зорилго, чиглэл ихээхэн тодорхой харагдаж байгаа юм.

Наполеон Бонапарт тухайн үедээ Хятадыг дүрслэхдээ "Тэнд аварга луу унтаж байна. Тэгээд л унтаж бай. Тэр сэрвэл дэлхийг Донсолгоно" гэсэн билээ.<sup>14</sup> Тэгвэл өнөөдөр Хятад сэрчихэж. Сэрэхээр барахгүй нум саалдаа агсчихаж. Энэ үед хэн түүний геополитикийн улга учир, далд санааг ойлгож байнав, тэр XXI зуунд эвийг нь олж, гарах аюулыг гэтгэж чадмой. Харин Монголын хувьд гэвэл, "Гуравдахь түншүүд"-ийн хязгаарлагдмал ашиг сонирхлыг нутагтаа бий болгож, эвсэлд нэгдээгүй орнуудын дотор нэр хүндээ бэхжүүлж, НУБ-ын бололцоог идэвхтэй ашиглаж, хоёр хөршийнхөө хувьд төвийг сахиж, аюулгүй байдлын цэргийн бүс асуудлуудыг шийдвэрлэхэд хүч, нөөцөө дайчлан ажиллах ёстой болов уу. Геополитикийн тэнцвэрт байдал бий болгох, түүний хамт их гүрнүүдийн өрсөлдөөн, сөргөлдөөний талбар болохгүй байхыг чухалчилж байхыг түүх сургажмилж байна.

#### Товч дүгнэхэд:

1. БНХАУ-ын зүгээс ойрын хэдэн арван жилд цэрэг, зэвсгийн түрэмгийлэл гарахгүй гэж үзэж байна. Энэ нь хил нийлсэн олон оронтой хийсээр ирсэн газар нутгийн маргаанаа хойш тавьж эдийн засгийн шинэчлэл, өөрчлөлт, нээлттэй бодлогоо хэрэгжүүлэхэд нэн анхаарч хөгжлийн таатай гадаад нөхцлийг эргэн тойрондоо бий болгоход чиглэсэн бодлогоос нь харалдана. Нөгөөтэйгүүр, өнөөгийн олон улсын харилцааны уур амьсгалыг геополитиктоо бодолцохгүй байхын аргагүй юм. Харин ОХУ-ын хүч, нөлөө суларсныг ашиглан, Монголд эдийн засгийн талаар нэвтрэх, нөлөөгөө хүчтэй болгоход ихээхэн анхаарч буй нь мэдрэгдсээр байна.
2. Хүн амын цагаачлал нь нэмэгдэж, соёлын түрэлт гэсэн өөр нэг "шар аюул" гарч ирсэн нь Хятадын геополитикийн "мөлхөө зэвсэг" болсоор удаж буйг төрийн геополитиктоо бид эрхбиш тусгаж, хариу бодлого боловсруулан хэрэгжүүлэх

- шаардлагатай болжээ.
3. БНХАУ Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хүндэтгэн зөвшөөрч буйгаа төр, засгийн дээд хэмжээнд нотолсоор байгаа ч "хар хайрцаг"-ны бодлогыг нь манай улс төрчид, судлаачид, дипломат нар гүнзгийрүүлэн судалсаар байх ёстой. Үүнтэй холбогдуулан ОХУ-д 1999 онд хэвлэгдсэн "Геополитика" гэсэн сурах бичгээс иш татъя: "...Гадаад Монголын хувьд гэвэл, тэдэнд газар нутаг хэрэггүй, амьдрах орон зай тэдэнд хүрэлцээтэй. Гэвч өмнө талаас хүчит хөрш-Хятад тулж байгаа билээ. Түүний түрэмгийлэн эзлэх бодлого хаашаа явах вэ? Москвад үүнийг мэдэхгүйн адил Улаанбаатарт ч бас мэдэхгүй байна. <sup>15</sup> Үүнийг манай улс төрийн удирдлага, гадаад бодлогын жолоог баригчид үйл ажиллагаа, бодлого, төсөөлөлдөө үргэлж анхаарч "мэдэхгүй" биш болгох ёстой буй заа.

## Тайлбар зүүлт:

1. Дэн Сяопин сканьзи (Сообр. сочинений Дэн Сяопина), Бээжин, 1993, х.293 (Ю.Гарушянцийн бичсэн "Борьба за признание независимости Монголии" өгүүллээс иш татав. "Проблемы Дальнего Востока", №2, 1997г. с. 122)
2. Edgar Snow, Red Star Over China (N.Y., Random House, 1938), footnote 1 on pp. 88-89 (quotation by Elizabeth E. Green)
3. Энэ тухай Хятадад хэвлэгдсэн "Закулисная сторона независимости Внешней Монголии" номонд дэлгэрэнгүй бичсэнийг Владимир Скосырев, "Дайджест" (№238, 11 дек. 1993г.) сонинд бичжээ.
4. Х.Олзвой "Монголын геополитик, хөгжлийн 1990-ээд оны онцлог" өгүүлэлд энэ талаар арай дэлгэрэнгүй байгаа. "Дорно-Өрнө" №1,2, 1997 он.
5. Japan Policy Research Institute, University of Victoria, Working Paper No 62. Robert Bedeski, "The Chinese Diaspora, Mongolia and the Sino-Russian Frontier", November 1999 p.3
6. Vladimir Shlapentokh "Russia, China, and the Far East: Old Geopolitics or a New Peaceful Cooperation?", Communist and Post-Communist Studies, Vol. 28, No.3 p.310
7. Elizabeth E. Green, China and Mongolia: Resurging Trends and Prospects

- for Change. Asian Survey, Vol. XXVI, No.12, December 1986, p.1337
8. Збигинев Ежезинский, "Великая Шахматная доска", М., "Международные отношения", 1998, с.196
9. Мэн тэнд, с.198
10. Дээрх ном, с.198-199
11. Академич Н.Ишжамц, Монголын түүхийн зарим өгүүллийн эмхэтгэл, Улаанбаатар, 1998 он, х.92
12. Samuel S.Kim "China As a Great Power" (See in: "The China Reader. The Reform Era" edited by Orville Schell and David Shambaugh, 19998 p.452)
13. А.Дугин Основы геополитики: Геополитическое будущее России. М.1999
14. Gannes H. Wahn, China likes N.Y., 1937, p.3. Н.А.Нартов Геополитика, М. 1999, с. 235
15. Н.А.Нартов, "Геополитика". Учебник, юнити, Москва, 1999, с.240